

СҮРЬЕЭТЭЙ ТЭМЦЭХ, СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ СТРАТЕГИ

(2010-2015 ОН)

Улаанбаатар хот
2009



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ**

2009 оны 8 сарын 24 өдөр

Дугаар 272

Улаанбаатар хот

**“Сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх
үндэсний стратеги” батлах тухай**

Засгийн газрын тухай хуулийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.8 дахь заалт, Засгийн газрын 2002 оны 129 тоот тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1. 2010-2015 онд хэрэгжүүлэх “Сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх Үндэсний стратеги”-ийг нэгдүгээр, стратегийг 2010-2011 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Стратегийг хэрэгжүүлэхэд шаардагдах олон улсын байгууллага, хандивлагчдын зээл, тусламжийг зөв зохицуулах, дотоодын эх үүсвэрээс гаргах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Н.Түмэндэмбэрэл)-т үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Н.Хүрэлбаатар)-д даалгасугай.



С.ЛАМБАА



СҮРЬЕЭТЭЙ ТЭМЦЭХ, СЭРГИЙЛЭХ ҮНДЭСНИЙ СТРАТЕГИ

НЭГ. ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА

1.1. Сүрьеэ өвчний дэлхий дахины болон бүсийн байдал

Сүрьеэ бол *Mycobacterium tuberculosis* нянгаар үүсгэгддэг, амьсгалын замаар тархдаг нийгмийн халдварт өвчин. Хэдийгээр сүрьеэгийн нянг нээснээс хойш 120 жил, эмчлэх эмийг гарган авснаас хойш 70 гаруй жил өнгөрсөн боловч сүрьеэ өвчний тархалт хэвээр, хүмүүс нас барсаар байна. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын тооцоолсноор жил бүр дэлхийд 9 сая гаруй хүн шинээр сүрьеэгээр өвчилж, 1.6 сая гаруй хүн нас барж байна¹.

1990-оны үеэс сүрьеэ өвчин дахин сэргэж байгаа бөгөөд ДЭМБ-ын тооцоолсноор Номхон далайн баруун бүс (НДББ)-д 2006 онд 1.9 сая хүн өвчилжээ². НДББ-ийн хэмжээнд бүртгэгдсэн сүрьеэгийн нийт тохиолдлын 95—аас дээш хувь нь Кампучи, Филиппин, Вьетнам, Хятад, Лаос, Шинэ Гвиней, Монгол зэрэг 7 оронд тохиолдож байна³.

Ядуурал, амьдралын хүнд нөхцөл, ажилгүйдэл, сүрьеэ/ХДХВ-ийн хавсарсан халдвар, олон эмэнд дасалтай сүрьеэ, эрүүл мэндийн тогтолцооны гажуудал зэрэг нь сүрьеэ өвчин дахин сэргэн тархахад түлхэц болж байна.

ДЭМБ-ын Бүсийн хорооноос баталсан “Номхон далайн баруун эргийн бүсийн сүрьеэтэй тэмцэх 2006-2010 оны стратеги төлөвлөгөө” нь бүсийн хэмжээнд бодит өөрчлөлт, амжилтуудыг авчирч байгаа ба бүсийн зорилго нь шууд хяналттай богино хугацааны эмчилгээг дэмжих, чанарыг сайжруулах, эрт илрүүлэлт ба эмчилгээний харьцааг “70/85” болгох, сүрьеэтэй өвчтөнүүдэд чанартай эмчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх, олон эмэнд дасалтай сүрьеэ болон сүрьеэ/ХДХВ-ийн хавсарсан халдварын эмчилгээг өргөжүүлэхэд чиглэгдэж байгаа юм.

¹ ДЭМБ. Дэлхийн сүрьеэгийн тайлан. 2009

² ДЭМБ НДББ-ийн сүрьеэгийн тайлан, 2008

³ ДЭМБ. НДББ. Сүрьеэтэй тэмцэх стратеги 2006-2010

1.2. Монгол улсын сүрьеэгийн өвчлөлийн өнөөгийн байдал, ололт амжилт


1.2.1 Сүрьеэгийн өвчлөл, тархалт

Сүрьеэгийн өвчлөл, нас баралт нь манай улсын эрүүл мэндийн салбарын тулгамдсан асуудал хэвээр байна. Монгол улс нь НДББ – ийн 37 орноос сүрьеэгийн өвчлөл өндөртэй 7 орны тоонд орж байгаа бөгөөд сүрьеэ манай улсын хүн амын нас баралтын шалтгааны 6 дугаарт орж байна⁴.

2008 онд сүрьеэгийн 4223 шинэ тохиолдол илэрч, үүнээс 1838 уушигны түрхэц эерэг тохиолдол бүртгэгдсэн байна. Өнөөгийн байдлаар түрхэц эерэг сүрьеэгийн тохиолдлын илрүүлэлт 83.5 хувь, эмчилгээний амжилт 89,0 хувь болж, Монгол улс НДББ – ийн хэмжээнд тавьсан зорилтуудыг биелүүлж чадсан.

ДЭМБ-ын тооцоолсноор 2007 онд сүрьеэгийн тархалт 100 000 хүн амд 234, нас баралтын түвшин 100 000 хүн амд 29 байгаа нь 2000 онтой харьцуулахад буурсан үзүүлэлт юм.

Зураг 1. Бүртгэгдсэн тохиолдол 2000 – 2008



Шинээр илэрсэн сүрьеэгийн тохиолдлыг насаар нь авч үзвэл залуу хөдөлмөрийн насны буюу 16-44 насныхан 71%-ийг эзэлж байна. Хүйсний хувьд эрэгтэйчүүд 53%, эмэгтэйчүүд 47% тус тус эзэлж, хүйсний харьцаа 1.1:1.0 байна.

Улаанбаатар хотод 2008 онд сүрьеэгийн шинэ тохиолдол 2302 бүртгэгдсэн нь улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт тохиолдлын 54,5% юм.

⁴ Эрүүл мэндийн үзүүлэлт 2008

Улаанбаатар хотод бүртгэгдсэн нийт сүрьеэгийн тохиолдлын 2,7% хөдөө орон нутгаас түр оршин суугчид, 1,2%-ийг орон гэргүй, хаяггүй хүмүүс тус тус эзлэж байна. Сүүлийн үеийн судалгаагаар хорих ангид хүмүүжигчид дунд олон эмэнд дасалтай сүрьеэ нийт хүн амтай харьцуулахад 2-5 дахин өндөр, сүрьеэгээр өвчлөгсдийн 74% нь ядуу хүмүүс байна.

Зураг 2. Монгол улс дахь сүрьеэгийн бүртгэгдсэн тохиолдол газарзүйн байршлаар, 2008



Сүрьеэгийн шинэ тохиолдлын 58,7%-ийг уушигны, 41,3%-ийг уушигны бус эрхтэний сүрьеэ эзэлж, уушигны бус эрхтэний сүрьеэгийн хувь бүсийн дунджаас 7 дахин их байна.

2008 онд хүүхдийн сүрьеэгийн 426 тохиолдол бүртгэгдэж, энэ нь сүрьеэгийн нийт шинэ тохиолдлын 10,1%-ийг эзэлж байна. Үүнийг урьд оны үзүүлэлттэй харьцуулахад 44 тохиолдлоор цөөн боловч 0-15 насны хүүхдийн дунд сүрьеэгийн менингит болон тархмал хэлбэрийн сүрьеэгийн тохиолдол нэмэгджээ.

Хэдийгээр сүрьеэгийн тархалт 2007 оноос бага зэрэг буурч байгаа ч олон эмэнд дасалтай сүрьеэгийн өвчлөл нэмэгдэж байна. Эмийн даслын судалгаагаар сүрьеэгийн шинэ тохиолдлын дунд эмийн дасал 1% байхад давтан эмчлүүлэгсдийн дунд 28% байна. Сүрьеэгийн тандалт судалгааны алба (СТСА)-ны тооцоолсноор жилд олон эмэнд дасалтай сүрьеэгийн 161 тохиолдол гарч, 2003-2009 оны 5 дугаар сарын байдлаар олон эмэнд дасалтай сүрьеэтэй 453 өвчтөн оношлогдож үүнээс зөвхөн 295 нь хоёрдугаар эгнээний эмийн эмчилгээнд хамрагджээ.

Монгол улс ХДХВ-ийн халдварын бага тархалттай орон бөгөөд ДЭМБ-аас манай улсад 2007 онд сүрьеэ ХДХВ-ийн хавсарсан халдварын тархалт 0,1% гэж тооцоолжээ.

1.2.2 Сүрьеэтэй тэмцэх дэд хөтөлбөрийн хэрэгжилт, ололт амжилт

Манай улс 1994 оноос өмнө хүн амыг нийтээр нь рентген шинжилгээнд хамруулах замаар сүрьеэгийн илрүүлэлт, оношлогоог хийдэг байсан. Харин 1994 оноос эхлэн ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу шууд хяналттай богино хугацааны эмчилгээг нэвтрүүлсэн байна.

Монгол улсад сүрьеэгийн тусламж үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлж байна.

2008 онд Сүрьеэгийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэнд ДЭМБ-ын санхүүгийн болон мэргэжил аргагүйн дэмжлэгтэйгээр хамтарсан үнэлгээ хийж, хөтөлбөрийн ололт амжилт, бэрхшээл, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөмж гаргасан. Монгол улс 1994 оноос шууд хяналттай богино хугацааны эмчилгээг хэрэгжүүлснээс хойшхи 15 жилийн хугацаанд НДББ-ийн тавьсан зорилтод хүрч, өнөөгийн энэ амжилт нь манай улсад сүрьеэгийн тархалт, нас баралт буурахад нөлөөлсөн болно.

Сүүлийн 8 жилийн хугацаанд 2007 онд анх удаа сүрьеэгийн шинэ тохиолдлын үзүүлэлт буурч, түрхэц эерэг уушигны сүрьеэгийн тохиолдол 13 хувиар, өвчлөл 10 хувиар буурсан байна.

Засгийн газраас сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх ажилд зарцуулж байгаа санхүүжилтийг жил бүр нэмэгдүүлж, 2007 оноос эхлэн сүрьеэгийн эсрэг нэгдүгээр эгнээний эмийн санхүүжилтийн тодорхой хувийг гаргаж эхэлсэн.

Засгийн газраас олон улсын стандартын шаардлага хангасан чанарын баталгаатай сүрьеэгийн эмээр найдвартай хангах арга хэмжээ авч, жилд дунджаар 336 мянган ам. долларын эмийн хангамжийг олон улсын байгууллагаас хийж, өнөөгийн байдлаар оношлогдсон бүх өвчтөнд эмийг 100% үнэ төлбөргүйгээр олгож байна.

Төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа нэмэгдэж, хорих ангид хүмүүжигчид, орон гэргүй хүмүүст сүрьеэгийн тусламж үйлчилгээг өргөжүүлж, өрхийн эмнэлэг, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг татан оролцуулах санаачлагууд эхлээд байна.

1.3. Тулгамдсан асуудал

Сүрьеэтэй тэмцэх дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад олсон амжилтыг улам бататгах, сүрьеэгийн илрүүлэлт болон эдгэрэлтийн түвшинг нэмэгдүүлэхийн тулд цаашид олон асуудлуудыг шийдвэрлэх хэрэгтэй байна. Үүнд, алслагдсан орон нутагт болон эмзэг бүлгийнхэнд үзүүлж буй шууд хяналттай богино хугацааны эмчилгээний чанар, хүртээж хангалтгүй, сүрьеэгийн оношлогоо эмчилгээний болон хүний нөөцийн чадавхи сул,

сүрьеэгийн тусламж үйлчилгээ хэт төвлөрсөн, олон эмэнд дасалтай сүрьеэ, ялгаварлан гадуурхалт гэх мэт асуудлууд орж байна.

Сүрьеэгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахын тулд СТДХ-ийн үйл ажиллагааны уялдаа холбоо, менежментийг бүх түвшинд бэхжүүлэх нь чухал юм. Өнөөдөр үндэсний түвшинд СТДХ-ийг удирдан зохион байгуулах стратеги, бодлого болон техникийн зөвлөгөө өгөх чадавхи хязгаарлагдмал, нөгөө талаас орон нутагт сүрьеэгийн тусламж үйлчилгээ үзүүлж буй эмч, эмнэлгийн ажилтан хангалтгүй байна.

Сүрьеэгийн тусламж үзүүлж байгаа эмч нарт тогтвортой ажиллах урамшууллын механизм, өөрсдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх боломж үгүйлэгдэж байна. Мөн сүрьеэтэй тэмцэх ажилд бусад байгууллага, салбарын оролцоо сул, санхүүгийн нөөц хязгаарлагдмал, гадаад санхүүжилтээс хараат байдал зэрэг нь сүрьеэгийн тусламж үйлчилгээний тогтвортой байдлыг хангахад саад учруулж байна.

Өсгөврийн шинжилгээ хийх чадавхи хязгаарлагдмал байгаагаас уушигны түрхэц сөрөг, уушигны бус хэлбэрийн сүрьеэ болон хүүхдийн сүрьеэг оношлоход бэрхшээлтэй байна. Уушигны бус сүрьеэгийн зарим хэлбэрийг оношлох эд, эсийн шинжилгээ хийх тоног төхөөрөмж дутагдалтай байна.

2007 оны тайлангаар уушигны түрхэц эерэг сүрьеэгийн шинэ тохиолдлын 6% (119) - д нь эмчилгээ үр дүнгүй болсон бөгөөд энэ нь ДЭМБ-ын НДББ-ийн үзүүлэлт (1%) - тэй харьцуулахад 6 дахин их юм. Мөн эмчилгээний дараа дахилт өгч байгаа өвчтөний эзлэх хувь нэмэгдэж, 2008 онд 5,9% болсон нь НДББ-ийн үзүүлэлтээс 1,3 хувиар их байна.

Сүрьеэтэй тэмцэх дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж болзошгүй бэрхшээлтэй асуудлын нэг нь олон эмэнд дасалтай сүрьеэгийн тохиолдол нэмэгдэж байгаа явдал юм. Зарим эрүүл мэндийн байгууллага стандартын бус эмчилгээ хийж, эмийн сангаар сүрьеэгийн 1-р эгнээний эм зарж байгаа нь эмэнд дасалтай сүрьеэ үүсэх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Олон эмэнд дасалтай сүрьеэ нь эмэнд дасалгүй сүрьеэтэй харьцуулахад эмчилгээ нь өндөр үнэтэй, гаж нөлөө ихтэй, 2 ба түүнээс дээш жил эмчилгээ хийх шаардлагатай. 2003-2008 онд илэрсэн олон эмэнд дасалтай 421 өвчтөний 171 (43%) нь эмчилгээнд хамрагдаж, 113 (27%) нь эмчилгээнд орж чадалгүй нас барж, 121 (29%) нь эмчилгээ хийлгэхээр хүлээж байна. Энэ нь олон эмэнд дасалтай сүрьеэтэй өвчтөнийг хэвтүүлэн эмчлэх ор хүрэлцээгүй, амбулаториор эмчлэх чадавхи сул байгаатай холбоотой. Олон эмэнд дасалтай сүрьеэг эмчлэх эмнэлгийн орны тоог нэмэгдүүлэх, диспансерийн харьяа өдрийн эмчилгээний цэгийг олшруулах шаардлагатай байна.

Монголын нийгэмд сүрьеэтэй өвчтөнийг ялгаварлан гадуурхах явдал байсаар байна. Сүрьеэтэй өвчтөн төдийгүй тэдэнтэй ажилладаг эрүүл мэндийн ажилтнууд айдас, мэдээллийн хомсдол, дэмжих орчин, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагаа хангалтгүйн улмаас ялгаварлан гадуурхагдаж байна. Өнгөрсөн хугацаанд Монгол улсад сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх үйл ажиллагаа нь сүрьеэгийн оношлогоо, эмчилгээг сайжруулахад илүү чиглэж, хүн амын дунд сүрьеэ өвчний тухай зөв мэдлэг, хандлага бий болгох арга хэмжээ дутагдалтай байснаас ялгаварлан гадуурхалтыг бууруулж чадаагүй юм.

Ядуурал, ажилгүйдэл, хүн амын шилжилт хөдөлгөөн өсөн нэмэгдэж байгаа нь сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх, хянахад бэрхшээл учруулж байна. Иймд эмзэг бүлгийн, орон гэргүй, хаягийн бүртгэлгүй, хөдөлгөөнт хүн амд сүрьеэгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах шаардлагатай байна.

ХОЁР. АЛСЫН ХАРАА, ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН.

2.1. Алсын хараа

Монгол улсад сүрьеэгийн өвчлөлийг эрс бууруулж, 2050 он гэхэд сүрьеэгийн тохиолдлыг 1,000,000 хүн ам тутамд 1-ээс бага болгох дэлхийн сүрьеэтэй тэмцэх стратегийн зорилтод хүрнэ.

2.2. Зорилго:

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтыг хангаж, 2015 он гэхэд сүрьеэгийн тархалтыг 100,000 хүн амд 150, сүрьеэгийн нас баралтыг 100,000 хүн амд 15 болгож бууруулахад энэхүү стратегийн зорилго оршино.

2.3. Стратегийн зорилтууд, хүлээгдэж буй үр дүн.

Зорилт 1

Сүрьеэ өвчинтэй тэмцэх үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох;

Хүлээгдэж буй үр дүн 1

- Сүрьеэгийн тусламж үйлчилгээнд Засгийн газрын оролцоо, төрөөс зарцуулах санхүүжилтийн хэмжээ нэмэгдсэн байна.

- Сүрьеэгийн тусламж, үйлчилгээг үр дүнтэй үзүүлэхийг дэмжсэн бодлогын таатай орчин бүрдсэн байна.
- Хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөө боловсрогдон хэрэгжиж эхэлсэн байна.
- Сүрьеэгийн тусламж үйлчилгээ үзүүлж буй эмч мэргэжилтнүүдэд зориулсан дипломын өмнөх болон дараах сургалтын чанар дээшилсэн байна.
- Мэдээ мэдээллийн чанар хүртээмж, үнэн бодит байдал, үр дүнтэй хэрэглээ нэмэгдсэн байна.
- Халдвар хамгааллын шаардлага хангасан ажлын байр нэмэгдсэн байна.

Зорилт 2

Эрт илрүүлэлт болон шууд хяналттай богино хугацааны эмчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах;

Хүлээгдэж буй үр дүн 2

- Эмнэлэгт хэвтүүлэх болон амбулаториор эмчлэх шалгуур үзүүлэлт боловсрогдож, сүрьеэгийн эрт илрүүлэлт, оношийн баталгаажилт, эмчилгээний үр дүн дээшилсэн байна.
- Аймаг, дүүрэг, суманд лабораторийн чадавхи бэхжиж, сорьц тээвэрлэх тогтолцоо бүрдсэн байна.
- Сүрьеэгийн эмээр тасралтгүй хангах механизм, эмийн менежмент сайжирсан байна.
- Сүрьеэ ба ХДХВ/ДОХ- той тэмцэх хөтөлбөрийн хамтын ажиллагаа сайжирсан байна.
- ХДХВ/ДОХ-той өвчтөнүүдийн дунд сүрьеэгийн илрүүлэлт сайжирсан байна.
- Сүрьеэтэй өвчтөнүүдийг ХДХВ-ийн халдварыг илрүүлэх шинжилгээнд бүрэн хамруулдаг болсон байна.

Зорилт 3

Олон эмэнд дасалтай сүрьеэг эрт илрүүлэх, тусламж үйлчилгээг өргөжүүлэх;

Хүлээгдэж буй үр дүн 3

- Олон эмэнд дасалтай сүрьеэг эрт илрүүлэх лабораторийн чадавхи сайжирсан байна.
- Олон эмэнд дасалтай сүрьеэтэй өвчтөнүүд цаг алдалгүй эмчилгээнд хамрагдаж, эмчилгээний үед үзүүлэх дэмжлэг нэмэгдсэн байна.

Зорилт 4

Сүрьеэгээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, ялгаварлан гадуурхалтыг бууруулах;

Хүлээгдэж буй үр дүн 4

- Хүн амын сүрьеэгийн талаарх мэдлэг, дадал, хандлага дээшилсэн байна.
- Сүрьеэгээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд хамт олны оролцоо сайжирсан байна.

Зорилт 5

Нийт хүн амд сүрьеэгийн чанартай тусламж үйлчилгээг тэгш хүргэх;

Хүлээгдэж буй үр дүн 5

- Алслагдсан нутагт шууд хяналттай богино хугацааны эмчилгээний чанар, хүртээмж сайжирсан байна.
- Эмзэг бүлгийн хүн амд хүргэх сүрьеэгийн тусламж өргөжсөн байна.

ГУРАВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Зорилт 1-ийн хүрээнд:

Бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарт чиглэсэн ухуулга, нөлөөллийн үйл ажиллагааг идэвхижүүлж, бодлого эрхзүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр:

Бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарт чиглэсэн ухуулга сурталчилгаа нь хүлээгдэж буй үр дүнд хүрэх гол стратегийн нэг байна. Сүрьеэгийн асуудлыг бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарын анхаарлын төвд байлгах зорилгоор удаан хугацааны үр дүнтэй ухуулга сурталчилгаа, харилцааны төлөвлөгөө боловсруулна.

Сүрьеэгийн үндэсний стратегиар эрүүл мэндийн тусламж үйлчилгээ болон урьдчилан сэргийлэх үзлэгтэй холбоотой одоогоор мөрдөж буй бодлогын баримт бичгүүдэд үнэлгээ өгч, цаашид авах арга хэмжээг тодорхойлох ба өвчтөний хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого боловсруулах юм. Мөн нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, ажил үүргийн хуваарьт сүрьеэтэй тэмцэх асуудлыг тусгах замаар тэдгээрийн дэмжлэг, оролцоог сайжруулна.

Сүрьеэтэй тэмцэх асуудалд Ерөнхий сайдаар ахлуулсан Нийгмийн эрүүл мэндийн Үндэсний зөвлөлийн анхаарлыг хандуулах зорилгоор гишүүдийн дунд ухуулга нөлөөллийн ажлыг Эрүүл Мэндийн Яамнаас зохион байгуулна.

Мэдээлэл, хяналт – шинжилгээ, үнэлгээний тогтолцоог сайжруулах чиглэлээр:

Монгол улсад сүрьеэгийн мэдээг ДЭМБ-ын бүртгэл мэдээллийн маягыг ашиглан цуглуулдаг. Гэвч бүртгэл мэдээллийн маягууд ДЭМБ-ын 2006 оны зөвлөмжийн дагуу шинэчлэгдээгүй байгаа юм. Иймд СТСА ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу сүрьеэгийн сэжигтэй тохиолдол, сүрьеэгийн тохиолдол, лабораторийн бүртгэл, эмчилгээний үр дүнгийн улирлын тайлан, олон эмэнд дасалтай сүрьеэгийн тохиолдлын бүртгэл, эмийн захиалга зэрэг бүртгэл мэдээллийн маягыг шинэчлэнэ. Мэдээний чанар, хүртээмж, мэдээг шийдвэр гаргахад хэрэглэх явдлыг сайжруулахын тулд сүрьеэгийн тандалт судалгаа, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцооны өнөөгийн байдалд үнэлгээ хийж, боловсронгуй болгох төлөвлөгөө боловсруулна. Мөн уушигны бус сүрьеэ, хүүхдийн сүрьеэгийн тохиолдлын тодорхойлолтыг стандартчилж, мэдээний үнэн зөв, бодит байдал, чанарыг сайжруулахын тулд цахим мэдээллийн тогтолцоог нэвтрүүлж, хэрэглэгчдийг сургалтад хамруулна.

Сүрьеэтэй тэмцэх үйл ажиллагааг нотолгоонд суурилан хэрэгжүүлэхийн тулд Монгол улс дахь сүрьеэгийн тархвар зүйн талаар үнэн зөв, бодит мэдээлэлтэй байх нь чухал. Одоогоор сүрьеэгийн судалгааны ажлыг системтэйгээр хийх тогтолцоо үгүй байна. Иймд үндэсний түвшинд судалгаа хийх чадавхийг бэхжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэх юм. Зарим судалгаа, тухайлбал, хүн ам дахь сүрьеэгийн тархалт, эмийн даслын судалгаа, эмч эмнэлгийн ажилтнууд болон хүн амын сүрьеэгийн талаарх мэдлэг, хандлага, дадлын өнөөгийн байдал, нас баралтын дүн шинжилгээ зэргийг үндэсний их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран гүйцэтгэнэ.

Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлж, эмч мэргэжилтнээр тогтвортой хангах чиглэлээр:

Хүний нөөцийн хүртээмж, ур чадвар, туршлага хангалтгүй байгаа нь сүрьеэгийн тусламж үйлчилгээг чанартай хүргэхэд сөргөөр нөлөөлж байна. иймд сүрьеэгийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлон, хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулна. Мөн төвийн түвшинд ажиллаж буй сүрьеэгийн мэргэжилтнүүдийн удирдах ур чадварыг сайжруулах, сүрьеэгийн эмч мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг хангах хөшүүрэг бий болгоход чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх юм.

Сүрьеэгийн эмч, мэргэжилтнүүдийн чадавхийг тасралтгүй сайжруулах хүрээнд улс, хувийн хэвшлийн анагаахын сургуулиудын дипломын өмнөх болон дараах сүрьеэгийн сургалтын хөтөлбөр, чанарт үнэлгээ хийж, шинэчлэнэ. Мөн мэргэшүүлэх болон давтан сургах стандартыг боловсруулан хэрэгжүүлнэ. Сүрьеэгээр өвчилсөн сүрьеэгийн эмч, эмнэлгийн ажилчдыг нийгмийн халамжинд хамруулах талаар зөвшилцөх уулзалт зохион байгуулах, холбогдох журамд өөрчлөлт оруулах зэрэг ажлуудыг хийнэ.

Зорилт 2-ын хүрээнд:

Лабораторийн чадавхийг бэхжүүлэх замаар шууд хяналттай богино хугацааны эмчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр:

Сүрьеэгийн өвчлөл өндөртэй аймаг, бүсийн оношлогоо эмчилгээний төвүүдэд өсгөвөрлөх шинжилгээний нэгжийг байгуулна. Зарим сум, орон нутгийн түвшинд түрхэцийн шинжилгээний лаборатори байгуулах нөхцөл бололцоог судлан шийдвэрлэнэ. Үндэсний лавлах лабораторийг шингэн тэжээлт орчин, молекул биологийн орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангана.

Лабораторийн урвалж бодисын ханган нийлүүлэлт, гадаад чанарын хяналтын тогтолцооны гарын авлага, үйл ажиллагааны стандартыг боловсруулж, нэгдсэн эмнэлгүүдийн лабораторийг түрхэцийн чанарын хяналтын тогтолцоонд хамруулах арга хэмжээ авна.

Сум, өрхийн эмнэлгээс аймаг, дүүргийн сүрьеэгийн лаборатори руу сорьц тээвэрлэх журам боловсруулж, давтан эмчилгээнд орж байгаа өвчтөнүүдийн сорьцыг сүрьеэгийн лавлах лаборатори руу тээвэрлэх тогтолцоог бүрдүүлнэ.

Мөн уушигны бус сүрьеэгийн оношлогоог сайжруулах зорилгоор эд, эсийн шинжилгээний тоног төхөөрөмжөөр хангаж, эмч мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулах юм.

Эмчилгээний чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр:

Эрт илрүүлэлт болон шууд хяналттай богино хугацааны эмчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах нэг гол нөхцөл нь эмнэлэгт хэвтүүлэх болон амбулаториор эмчлэх шалгуур үзүүлэлтийг боловсруулж, хэрэгжүүлэх явдал юм. Ингэснээр сүрьеэгийн түрхэц эерэг шинэ тохиолдлын эмчилгээ сайжирч, олон эмэнд дасалтай сүрьеэгийн орны тоог нэмэгдүүлэх боломж бүрдэх юм.

Дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн харьяа амбулаториудад сүрьеэгийн эмчилгээ, хяналтын цэгүүдийг нэмж байгуулан, сүрьеэтэй өвчтөнүүдэд сайн дурын идэвхтэнээр дамжуулан хүргэж буй гэрийн болон хоолтой эмчилгээний өнөөгийн байдалд үнэлгээ хийж, сайжруулах арга хэмжээ авна. Сайн дурын идэвхтэнүүдэд зориулсан сургалтыг үргэлжлүүлэн зохион байгуулна.

Жирэмсний болон төрсний дараах үед сүрьеэг эрт илрүүлэх, хяналтыг сайжруулах, их, дээд сургууль, коллежийн оюутнуудын дунд сүрьеэг илрүүлэх хагас идэвхитэй үзлэг зохион байгуулах, сүрьеэтэй өвчтөнүүдийн хавьтлыг үзлэг шинжилгээнд хамруулах ажлыг төлөвлөгөөтэйгээр зохион байгуулна.

ДЭМБ-ын стандартад нийцүүлэн хавьтлын менежментийн удирдамж боловсруулж, сургалт зохион байгуулах юм.

Эмийн менежментийг боловсронгуй болгох чиглэлээр:

Сүрьеэгийн эмийн менежментийг боловсронгуй болгож, сүрьеэгийн 1-р эгнээний эмээр тасралтгүй хангах, эмийг аймаг дүүргийн диспансерт түгээх зардлыг төсөвт суулгах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Эм тасалдах эрсдлийг бууруулах зорилгоор сүрьеэгийн эмийн нөөц бүрдүүлж, аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансерт эм хадгалах өрөөг стандартын дагуу тохижуулна. Мөн эмийн хадгалалт, захиалга, тооцоолох аргачлалд эмч, эмийн мэргэжилтнүүдийг сургана.

Сүрьеэгийн эмийн хүүхдийн тунг эмчилгээний практикт нэвтрүүлж эхэлнэ. Эмийн сангаар сүрьеэгийн эмийг худалдаалахыг хориглох чиглэлээр арга хэмжээ авна.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх чиглэлээр:

Эрүүл мэндийн салбарт хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэж байна. Цаашид ч өрхийн эмч, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын эмч мэргэжилтнүүдийг сүрьеэгийн тусламж үйлчилгээнд татан оролцуулах нь чухал байна. Глобаль сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй төр хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах туршилтын төслийн сургамж, үр дүнд

үндэслэн Улаанбаатар хотын 9 дүүрэг, зарим аймагт сүрьеэтэй тэмцэх сэргийлэх ажилд төр хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлнэ.

ХДХВ/ДОХ, сүрьеэтэй тэмцэх хөтөлбөрийн хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр:

Сүрьеэ/ХДХВ-ийн хавсарсан халдварын үед үзүүлэх тусламж, үйлчилгээний удирдамж боловсруулж хэрэгжүүлнэ. Ингэснээр сүрьеэтэй хүмүүсийг үйлчилгээ үзүүлэгчийн санаачлагаар ХДХВ-ийн халдварыг илрүүлэх шинжилгээнд бүрэн хамруулж, изониазидын урьдчилан сэргийлэх эмчилгээ, мөн сүрьеэ/ХДХВ-ийн хавсарсан халдвартай хүмүүст дагалдах халдвараас урьдчилан сэргийлэх эмчилгээ хийх аргыг нэвтрүүлнэ. Үүнээс гадна сүрьеэгийн эмч, мэргэжилтнүүдэд ХДХВ-ийн халдвар илрүүлэх зөвлөгөө, шинжилгээ хийх чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулна. ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн ба ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны албадын хооронд хавсарсан халдварын бүртгэл мэдээллийг харилцан солилцох тогтолцоог бий болгоно.

Зорилт 3-ын хүрээнд:

Олон эмэнд дасалтай сүрьеэгийн оношлогоо, эмчилгээг сайжруулах, өргөжүүлэх чиглэлээр:

ОЭДС-тэй тэмцэх үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалтыг сайжруулах гол стратеги нь үндэсний түвшинд олон эмэнд дасалтай сүрьеэгийн тандалт судалгааны чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх асуудал юм. Ингэснээр ОЭДС-ийн менежментийн зохицуулалт сайжирч, сүрьеэгийн эмч, мэргэжилтнүүдийг мэргэжил аргагүйн удирдлагаар хангах, сургалт, судалгааны ажлын цар хүрээ нэмэгдэнэ.

Сүрьеэгийн өвчлөл өндөртэй аймаг болон бүсийн оношлогоо эмчилгээний төвүүдэд өсгөвөрлөх шинжилгээний нэгжийг байгуулах юм. Сүрьеэгийн лавлагаа лаборатори нь сүрьеэгийн шинэ тохиолдлуудын дунд эмийн даслын түвшинг тодорхойлох судалгааг үргэлжлүүлэн хийнэ. Хөдөө орон нутагт ОЭДС-ийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор давтан эмчилгээнд хамрагдсан өвчтөнүүдийн сорьцыг аймаг, дүүргээс сүрьеэгийн лавлагаа лабораторид илгээх тогтолцоог бүрдүүлнэ.

ОЭДС-ийн эмчилгээний хамралт, үр дүнг сайжруулах арга хэмжээ авна. Үүний тулд ОЭДС-тэй өвчтөнийг эмчлэх, халдвар хамгааллын дэглэмийн шаардлага хангасан эмнэлгийн орны тоог нэмэгдүүлж, амбулаторийн өдрийн эмчилгээний цэгүүдийг шинээр байгуулна. Халдвар хамгааллын өнөөгийн байдалд үнэлгээ өгч, сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан, эрүүл мэндийн ажилтнуудад энэ чиглэлээр сургалтуудыг

зохион байгуулна. Мөн сүрьеэгийн 2-р эгнээний эмийн даслын судалгааг эхлүүлж, эмээр тасралтгүй хангах арга хэмжээ авна.

ОЭДС-тэй өвчтөнүүдийн дунд хавьтал илрүүлэлтийг сайжруулна.

Хорих ангид хүмүүжигчдийн дунд илэрсэн сүрьеэгийн бүх тохиолдлыг өсгөврийн шинжилгээнд тогтмол хамруулах механизмыг бий болгоно.

ОЭДС-тэй өвчтөнүүдэд нийгмийн халамжийн дэмжлэг үзүүлэх боломжийг судлан шийдвэрлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Зорилт 4-ийн хүрээнд:

Зан үйлийг өөрчлөх мэдээлэл, сургалт, сурталчилгааны чиглэлээр:

Нийт хүн ам болон эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын дунд сүрьеэтэй өвчтөнүүдийг ялгаварлан гадуурхахтай холбоотой мэдлэг, хандлага, дадлын судалгаа явуулж, судалгааны дүнг үндэслэн ялгаварлан гадуурхалтыг бууруулах, зан үйлийг өөрчлөх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ. Ялгаварлан гадуурхалтыг бууруулах ажлыг олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглах замаар төрийн ба төрийн бус байгууллага, олон нийт, аж ахуйн нэгж, хувь хүмүүсийн оролцоотойгоор гүйцэтгэнэ.

Зорилт 5-ын хүрээнд:

Алслагдмал нутаг дэвсгэрт шууд хяналттай богино хугацааны эмчилгээний хүртээмжийг сайжруулах чиглэлээр:

Алслагдсан орон нутаг болон гэр хороололд амьдарч буй сүрьеэтэй өвчтөнүүд шууд хяналттай богино хугацааны эмчилгээнд хамрагдахад ихээхэн бэрхшээлтэй тулгарч байна. Сумаас аймаг руу, аймгаас үндэсний төв лабораторид сорьц тээвэрлэх тогтолцоог бүрдүүлж, бэхжүүлэх нь сүрьеэгийн оношлогоог үйлчлүүлэгчдэд ойртуулах чухал ач холбогдолтой юм. Сүрьеэгийн үндэсний лавлагаа лаборатори нь сорьц тээвэрлэх тогтолцоог аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансерт бүрдүүлэхэд техникийн дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

Хүндэрсэн хэлбэрийн сүрьеэ болон шууд хяналттай эмчилгээнд хамрагдаж ирж чадахгүй байгаа өвчтөнүүдэд эмчилгээг гэрээр хүргэх мөн нэмэлт хүнс шаардлагатай, ажилгүй, орлого багатай өвчтөнүүдэд хоолтой, шууд хяналттай эмчилгээ хийх санаачлагыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Эмзэг бүлгийн хүмүүст үзүүлэх тусламж үйлчилгээг өргөжүүлэх чиглэлээр:

Сүрьеэгийн тусламж үйлчилгээг орон гэргүй хүмүүс, хорих ангийн хүмүүжигчид, хөдөлгөөнт хүн амд үзүүлэхэд эрүүл мэндээс бусад салбарын

оролцоо нэн чухал. Хэдийгээр эмзэг бүлгийнхэнд чиглэсэн сүрьеэтэй тэмцэх үйл ажиллагааг орон нутгийн засаг захиргааны байгууллага, олон улсын болон төрийн бус байгууллагууд Глобаль сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байгаа боловч цар хүрээ нь хязгаарлагдмал байна. Иймд Хуульзүй, дотоод хэргийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны оролцоотойгоор энэхүү үйл ажиллагааг өргөжүүлнэ.

Хорих анги дахь сүрьеэгийн тусламж үйлчилгээний зохицуулалтыг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ. Хорих ангийн ажилтнуудад сүрьеэгийн талаар ухуулга сурталчилгаа, чадавхи бэхжүүлэх сургалт зохион байгуулах юм. Мөн хорих ангийн хүмүүжигчид, орон гэргүй хүмүүсийг хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр хангах өнөөгийн үйл ажиллагааг үргэлжлүүлнэ.

ДӨРӨВ: СТРАТЕГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Сүрьеэтэй тэмцэх үндэсний стратегийг 2010-2015 онд хэрэгжүүлнэ. Стратегийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, оролцогч байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүргийг Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар гүйцэтгэнэ.

Стратегийг хэрэгжүүлэхэд Хууль, зүй дотоод хэргийн яам, Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам, аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар, Эрүүл мэндийн газар бусад төрийн ба төрийн бус байгууллага, олон улсын түншүүдтэй хамтран ажиллана.

ТАВ: САНХҮҮГИЙН ХЭРЭГЦЭЭ

Сүрьеэтэй тэмцэх, сэргийлэх үндэсний стратегийг 2010-2011 онд хэрэгжүүлэхэд 5,6 сая доллар шаардагдана. Санхүүжилтийн тодорхой хувийг Глобаль сангийн дэмжлэгтэй сүрьеэгийн төслөөс гарах бөгөөд 2010 онд 2,8 сая, 2011 онд 1,9 сая доллар төсөвлөгдсөн болно. Бусад санхүүжилтийг Засгийн газар, ДЭМБ, Дэлхийн зөн олон улсын байгууллага болон хувийн хэвшлийн байгууллагуудаас гаргах юм.

ЗУРГАА: СТРАТЕГИЙН ХЯНАЛТ - ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Эрүүл мэндийн яам стратегийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хянахаас гадна МХЗ-д тусгагдсан сүрьеэгийн тархалт, нас баралтын түвшний чиг хандлагыг үнэлж, холбогдох газруудыг мэдээллээр хангана.

ДОЛОО: ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Алсын хараа	Монгол улсад сүрьеэгийн өвчлөлийг эрс бууруулж, 2050 он гэхэд сүрьеэгийн тохиолдлыг 1,000,000 хүн ам тутамд 1-ээс бага болгох дэлхийн сүрьеэтэй тэмцэх стратегийн зорилтод хүрнэ.	
Зорилго	Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтыг хангаж, 2015 он гэхэд сүрьеэгийн тархалтыг 100,000 хүн амд 150, сүрьеэгийн нас баралтыг 100,000 хүн амд 15 болгож бууруулахад энэхүү стратегийн зорилго оршино.	
Зорилт 1:	Сүрьеэ өвчинтэй тэмцэх үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох,	
Хүлээгдэж буй үр дүн	<ul style="list-style-type: none"> - Сүрьеэгийн тусламж үйлчилгээнд Засгийн газрын оролцоо, төрөөс зарцуулах санхүүжилтийн хэмжээ нэмэгдсэн байна. - Сүрьеэгийн тусламж, үйлчилгээг үр дүнтэй үзүүлэхийг дэмжсэн бодлогын таатай орчин бүрдсэн байна. - Хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөө боловсрогдон хэрэгжиж эхэлсэн байна. - Сүрьеэгийн тусламж үйлчилгээ үзүүлж буй эмч мэргэжилтнүүдэд зориулсан дипломын өмнөх болон дараах сургалтын чанар дээшилсэн байна. - Мэдээ мэдээллийн чанар хүртээмж, үнэн бодит байдал, үр дүнтэй хэрэглээ нэмэгдсэн байна. - Халдвар хамгааллын шаардлага хангасан ажлын байр нэмэгдсэн байна. 	
Үзүүлэлтүүд	2008 оны түвшин	2015 оны зорилт
Үзүүлэлт 1. Сүрьеэгийн тусламж үйлчилгээнд төрөөс зарцуулсан хөрөнгө	Суурь үзүүлэлтийг тогтооно.	10% нэмэгдүүлэх
Үзүүлэлт 2. Халдвар хамгааллын шаардлага хангасан ажлын байрны тоо	1	15
Үзүүлэлт 3. Мэдээллийн цахим сүлжээнд холбогдсон сүрьеэгийн нэгжийн хувь	0	100%

Зорилт 2.	Эрт илрүүлэлт болон шууд хяналттай богино хугацааны эмчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах	
Хүлээгдэж буй үр дүн	<ul style="list-style-type: none"> - Эмнэлэгт хэвтүүлэх болон амбулаториор эмчлэх шалгуур үзүүлэлт боловсрогдож, сүрьеэгийн эрт илрүүлэлт, оношийн баталгаажилт, эмчилгээний үр дүн дээшилсэн байна. - Аймаг, дүүрэг, суманд лабораторийн чадавхи бэхжиж, сорьц тээвэрлэх тогтолцоо бүрдсэн байна. - Сүрьеэгийн эмээр тасралтгүй хангах механизм, эмийн менежмент сайжирсан байна. - Сүрьеэ ба ХДХВ/ДОХ- той тэмцэх хөтөлбөрийн хамтын ажиллагаа сайжирсан байна. - ХДХВ/ДОХ-той өвчтөнүүдийн дунд сүрьеэгийн илрүүлэлт сайжирсан байна. - Сүрьеэтэй өвчтөнүүдийг ХДХВ-ийн халдварыг илрүүлэх шинжилгээнд бүрэн хамруулдаг болсон байна. 	
Үзүүлэлтүүд	Суурь үзүүлэлт	2015 оны зорилт
Үзүүлэлт 4. Түрхэц эерэг сүрьеэгийн тохиолдлын илрүүлэлтийн хувь	83,5%	85%
Үзүүлэлт 5. Түрхэц эерэг сүрьеэгийн шинэ тохиолдлын эдгэрэлтийн хувь	83.1%	85%
Үзүүлэлт 6. Шууд хяналттай богино хугацааны эмчилгээ хийж байгаа өрхийн эмнэлгийн хувь	0	50%
Үзүүлэлт 7. Уушгины түрхэц сөрөг болон уушигны бус хэлбэрийн сүрьеэгийн оношийн баталгаажилтын хувь	30%	60%
Үзүүлэлт 8. Түрхэц эерэг сүрьеэгийн шинэ тохиолдлын эмчилгээ үр дүнгүй болсон хувь	6.4%	< 5%
Үзүүлэлт 9. Сүрьеэгийн эмийн 3 сарын нөөцтэй аймгийн тоо	0	21
Үзүүлэлт 10. Сүрьеэгийн эм тээвэрлэх зардлыг төсөвтөө тусгасан аймгийн тоо	0	21

Үзүүлэлт 11. Сүрьеэгийн өсгөвөрлөх шинжилгээ хийдэг нэгжийн тоо	0	4
Үзүүлэлт 12. Түрхэцийн шинжилгээ хийдэг сумын эмнэлгийн тоо	16	30
Үзүүлэлт 13. ХДХВ –ин халдварыг илрүүлэх шинжилгээнд хамрагдсан сүрьеэтэй өвчтөний хувь	28%	75%
